

ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН САЛБАРЫН МЭРГЭШСЭН МЭРГЭЖИЛТЭН, ШИНЖЭЭЧИЙН ЭРХ ОЛГОХ АСУУДЛЫГ МЭРГЭЖЛИЙН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГААР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.26, 10 дугаар зүйлийн 10.1.16, 48 дугаар зүйлийн 48.12, Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын 3 дугаар зүйлийн 3.1.11, 3.7.6, 3.7.12 болон 4 дүгээр зүйлийн 4.3.9-д заасныг үндэслэн геологи, уул уурхайн салбарын мэргэжилтнүүдэд мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрх олгох асуудлыг мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх асуудлыг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Мэргэшсэн мэргэжилтэн нь Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.26 дах заалтад дурдсан шаардлагыг хангаж, мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрхийг олгох төрийн бус байгууллагаас эрх олгогдсон иргэнийг хэлэх бөгөөд мэргэшсэн, зөвлөх гэсэн мэргэшлийн зэрэгтэй байна.

1.3. Шинжээч нь геологийн судалгааны ажлын эцсийн үр дүнгийн тайлан /эрдэм шинжилгээ, зураглал, эрэл, хайгуул гм/, ашигт малтмалын ордыг ашиглах болон баяжуулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт гаргах эрх бүхий мэргэшсэн болон зөвлөх зэрэгтэй мэргэшсэн мэргэжилтэн байна.

Хоёр. Мэргэжлийн төрийн бус байгууллагад тавигдах шаардлага, үйл ажиллагааны чиглэл

2.1. Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (“төрийн захиргааны төв байгууллага” гэх) нь энэхүү журмын 2.3-д заасан шаардлагыг хангасан мэргэжлийн төрийн бус байгууллага (“төрийн бус байгууллага” гэх)-тай гэрээ байгуулж, эрх олгосны үндсэн дээр мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрх олгох асуудлыг гүйцэтгүүлнэ.

2.2. Төрийн бус байгууллага нь геологийн салбарын мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрх олгох болон уул уурхайн салбарын мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрх олгох гэж төрөлжсөн байна.

2.3. Төрийн бус байгууллага нь дараах шаардлагыг хангасан байна:

2.3.1. Төрийн бус байгууллагын зорилго нь геологи, уул уурхайн мэргэшлийн бүх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байх;

2.3.2. Геологи, уул уурхайн салбарт 5 (тав)-аас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан эсхүл төрийн бус байгууллагуудын гишүүнчлэлтэй нэгдсэн холбоо байх;

2.3.3. Мэргэшсэн болон зөвлөх мэргэжилтэн бэлтгэх стандартын шаардлага хангасан сургалтын танхим, лаборатори, сургалтын талбай (полигон), боловсон хүчний чадавхитай, сургалтын тодорхой хөтөлбөртэй байх эсхүл энэ шаардлагыг хангасан эрдэм шинжилгээ-сургалт-үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлдэг их сургуультай гэрээ байгуулсан байх;

2.3.4. Өөрийн гишүүдийг олон улсын түвшинд ажиллах нөхцөл бололцоогоор хангах, бусад улсын туршлагаас солилцох, мэргэжил дээшлүүлэх талаар тодорхой төлөвлөгөөтэй байх;

2.3.5. Геологи, уул уурхайн салбарын мэргэшсэн мэргэжилтний мэргэшлийн зэрэг олгох сургалт явуулах, шалгалт авах, мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрх олгох эрх бүхий мэргэшсэн мэргэжилтний зөвлөлтэй байх бөгөөд зөвлөлийн бүрэлдэхүүний гуравны хоёроос доошгүй хувь нь зөвлөх зэрэгтэй байх;

2.4. Энэхүү журмын 2.3 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан гэж үзэж буй төрийн бус байгууллага нь дараах баримт бичгүүдийг бүрдүүлэн Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ. Үүнд:

- Бичгээр гаргасан албан хүсэлт;
- Төрийн бус байгууллагын гэрчилгээ, дүрмийн хуулбар,
- Эрх авах хүсэлт гаргах талаарх төрийн бус байгууллагын удирдах зөвлөлийн шийдвэр;
- Сүүлийн 5 (тав) жилийн үйл ажиллагааны тайлан (эсхүл гишүүн төрийн бус байгууллагын тайлан);
- Төрийн бус байгууллагын гишүүний бүртгэл, гишүүнчлэлийг бүртгэсэн болохыг нотолсон баримт бичиг;
- Сургалтын танхим, лаборатори, сургалтын талбай (полигон)-тай болохыг гэрчилсэн баримт бичиг;
- Сургалт явуулах боловсон хүчний чадавхийн талаарх мэдээлэл;
- Сургалтын хөтөлбөр (мэргэшлийн чиглэл тус бүрээр);
- Сургалт явуулах асуудлаар эрдэм шинжилгээ-сургалт-үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлдэг их сургуультай гэрээ байгуулсан бол уг гэрээний эх хувийг;
- Гишүүдийг олон улсын түвшинд ажиллах нөхцөл бололцоогоор хангах, бусад улсын туршлагаас солилцох, тэдгээрийн мэргэшлийг дээшлүүлэх талаар боловсруулсан төлөвлөгөө;
- Мэргэшсэн мэргэжилтний зөвлөл байгуулах тухай шийдвэр, зөвлөлийн гишүүдийн анкет, зөвлөх зэргийн гэрчилгээний хуулбар.

2.5. Төрийн захиргааны төв байгууллага нь төрийн бус байгууллагаас ирүүлсэн баримт бичгийг ажлын 15 хоногийн дотор хянаж, шаардлагатай бол газар дээр нь шалгаж, баримт бичгийн бүрдлийг шалган тухайн төрийн бус байгууллагатай гэрээ байгуулах эсэх асуудлыг шийдвэрлэнэ. Шаардлага хангасан төрийн бус байгууллагатай 3 жилийн хугацаатай гэрээ байгуулна.

2.6. Мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрх олгох талаар Төрийн захиргааны төв байгууллагатай гэрээ байгуулсан төрийн бус байгууллага нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллана:

2.6.1. Геологийн салбарын мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрх олгох мэргэшлийн төрийн бус байгууллага нь уул уурхайн салбарын мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрхийг олгох, сургах, эрх цуцлах асуудлыг хэрэгжүүлэх бөгөөд геологийн

салбарын мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрх олгох мэргэжлийн төрийн бус байгууллага нь уул уурхайн салбарын мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрхийг олгох, сургах, эрх цуцлах асуудлыг хэрэгжүүлэх;

2.6.2. Өөрийн гишүүдийг олон улсын түвшинд гарч ажиллах, бусад улсын туршлагаас суралцах, туршлага солилцох, гишүүдийн мэдлэгийг байнга дээшлүүлэх нөхцөлийг хангаж, олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдөхөд нь дэмжлэг үзүүлэх;

2.6.3. Мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчдийн мэргэжлийн үйл ажиллагаандаа мөрдөх ёс зүйн дүрмийг энэхүү журамд нийцүүлэн батлах, ёс зүйн асуудлыг хэлэлцэх хороог байгуулах;

2.6.4. Эрдэс баялгийг зохистой ашиглахад үндэсний мэргэжилтнүүдийн оролцоог хангаж, хариуцлагыг нэмэгдүүлэх.

2.7. Төрийн бус байгууллага нь түүнтэй байгуулсан гэрээний хугацаа дуусгавар болохоос 3 сарын өмнө өөрийн үйл ажиллагааны 3 жилийн тайлан, эрх олгосон мэргэшсэн мэргэжилтнүүдийн жагсаалт, тэдгээрийн хийсэн геологийн судалгааны ажлын эцсийн үр дүнгийн тайлан /эрдэм шинжилгээ, зураглал, эрэл, хайгуул гм/, ашигт малтмалын ордыг ашиглах болон баяжуулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл нь Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэрхэн хэлэлцэгдэж байсан тухай мэдээллийн хамт ирүүлнэ. Төрийн захиргааны төв байгууллага нь ирүүлсэн материалыг хянан үзэж, тухайн хугацаанд үйл ажиллагаагаа хууль тогтоомж, гэрээнд заасан хүрээнд мэргэжлийн түвшинд явуулсан гэж үзвэл гэрээний хугацааг дахин 3 жилээр сунгана.

2.8. Төрийн бус байгууллага нь энэхүү журмаар болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй эсхүл мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрх олгох асуудлаар холбогдох хууль тогтоомж зөрчсөн болох нь тогтоогдсон тохиолдолд төрийн захиргааны төв байгууллага нь тухайн төрийн бус байгууллагатай байгуулсан гэрээг хугацаанаас нь өмнө цуцална.

Гурав. Мэргэшсэн мэргэжилтний зөвлөл

3.1. Төрийн бус байгууллага нь мэргэшсэн мэргэжилтний мэргэшлийн зэрэг олгох сургалтын хөтөлбөр боловсруулах, шалгалт авах, шинжээчийн эрх олгох тухай дүгнэлт гаргах мэргэшсэн мэргэжилтний зөвлөлтэй байх бөгөөд мэргэшсэн мэргэжилтний зөвлөлийн бүрэлдэхүүний гуравны хоёроос доошгүй хувийг 2 жил тутамд өөрчилнө.

3.2. Мэргэшсэн мэргэжилтний зөвлөл нь нийт 5-аас дээш хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд геологи, уул уурхайн мэргэжлийн чиглэлээр эрдэм шинжилгээ-сургалт-үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлдэг их сургуулийн төлөөллийг оролцуулсан байна. Энэхүү журмын 2.3.5 дахь хэсэгт заасны дагуу зөвлөлийн бүрэлдэхүүний гуравны хоёроос доошгүй хувь нь зөвлөх зэрэгтэй байна.

3.3. Мэргэшсэн мэргэжилтний зөвлөл нь нарийн бичгийн даргатай байх бөгөөд нарийн бичгийн дарга нь хуралдаанд санал өгөх эрхгүйгээр оролцож, зөвлөлийн дотоод үйл ажиллагааг зохион байгуулна.

Дөрөв. Мэргэшсэн мэргэжилтний эрх олгох сургалт зохион байгуулах, мэргэшсэн мэргэжилтний болон шинжээчийн эрх олгох болон цуцлах

4.1. Мэргэшсэн мэргэжилтний зэрэг горилогч нь дараах болзол, шалгуурыг хангасан байна:

4.1.1. геологи, уул уурхайн чиглэлээр их, дээд сургууль төгсөж, дээд боловсрол эзэмшсэн байх;

4.1.2. мэргэшсэн зэрэг горилогч нь бакалаврын боловсрол эзэмшсэнээс хойш тухайн мэргэшлийн чиглэлээрээ 5 болон түүнээс дээш жил ажилласан байх;

4.1.3. зөвлөх зэрэг горилогч нь мэргэжлээрээ 25 болон түүнээс дээш жил ажилласан, эсхүл мэргэшсэн зэрэг авснаас хойш 15 жил тогтвортой мэргэжлийн өндөр түвшинд ажилласан байх;

4.1.4 Мэргэшсэн болон зөвлөх мэргэшлийн зэргийг хугацаагүйгээр олгоно.

4.2. Энэхүү журмын 4.1-т заасан шаардлагыг хангасан иргэн нь тухайн салбарын мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрх олгохоор төрийн захиргааны төв байгууллагатай гэрээ байгуулсан аль нэг төрийн бус байгууллагын зүгээс санал болгож буй мэргэшсэн мэргэжилтний эрх олгох сургалтад суралцсаны үндсэн дээр шалгалтад оролцох эрхтэй болно.

4.3. Энэ журмын 4.2-д заасан сургалтыг тухайн төрийн бус байгууллага нь өөрийн баталсан хөтөлбөрийн дагуу танхимын, эрдэм шинжилгээний хурал, сургалт-семинар болон бусад хэлбэрээр зохион байгуулна.

4.4. Тухайн төрийн бус байгууллагын мэргэшсэн мэргэжилтний зөвлөл нь мэргэшсэн мэргэжилтний эрх олгох шалгалтыг өөрийн баталсан журмын дагуу явуулна.

4.5. Энэхүү журмын 4.2-т заасан сургалтад хамрагдсан, энэхүү журмын 4.1-д заасан шаардлагыг хангасан, мэргэшсэн мэргэжилтний зөвлөлөөс зохион байгуулсан шалгалтанд 70 болон түүнээс дээш хувийн үнэлгээ авсан зэрэг горилогчид төрийн бус байгууллагын мэргэшсэн мэргэжилтний зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн мэргэшлийн зэрэг олгож, мэргэжлийн гэрчилгээ, батламж, хувийн тэмдэг олгоно.

4.6. Геологи, уул уурхайн мэргэжлийн чиглэлээр боловсролын болон шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан эсхүл геологи, уул уурхайн салбарт 25-аас доошгүй жил тасралтгүй, үр бүтээлтэй ажилласан мэргэжилтэнд өөрийнх нь бичгээр уламжилсан хүсэлтийг үндэслэн мэргэшсэн мэргэжилтний зөвлөл бүтээлийг нь үнэлэх замаар мэргэшлийн зэргийг олгож болно.

4.7. Мэргэшсэн мэргэжилтний эрхийг дараах тохиолдолд төрийн бус байгууллагын мэргэшсэн мэргэжилтний зөвлөлийн хуралдааны шийдвэрээр цуцална. Үүнд:

4.7.1. Тухайн мэргэшсэн мэргэжилтэн, зөвлөхийн зохиосон, зөвлөсөн геологийн судалгааны ажлын эцсийн үр дүнгийн тайлан /эрдэм шинжилгээ, зураглал, эрэл, хайгуул гм/ болон техник эдийн засгийн үндэслэл нь 3 болон түүнээс дээш удаа хууль тогтоомжоор тавигдсан шаардлагыг хангаагүй буцаагдсан, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл хүлээн авахаас татгалзсан эсхүл энэхүү журмын 6.2-т заасныг зөрчсөн тухай Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн тэмдэглэлд дурьдагдсан бол Эрдэс баялгийн мэргэжлийн даргын саналыг үндэслэж;

4.7.2. Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг зөрчсөн тохиолдолд мэргэшлийн зэргийг төрийн бус байгууллагын ёс зүй ба гомдол хэлэлцэх хороо, мэргэшсэн мэргэжилтний зөвлөлийн саналыг үндэслэж;

4.8. Эрх нь цуцлагдсан мэргэшсэн мэргэжилтэн нь тухайн эрх цуцлагдсан өдрөөс хойш 2 жилийн дараа дахин сургалтад хамрагдаж, эрх олгох шалгалтад оролцох хүсэлт гаргах эрхтэй.

Тав. Шинжээчийн эрх олгох, шинжээчид тавигдах шаардлага

5.1. Мэргэшсэн мэргэжилтний бичгээр уламжилсан өөрийн мэргэшлийн чиглэлээр шинжээчээр ажиллах хүсэлтийг үндэслэн төрийн бус байгууллага нь шинжээчийн эрх олгоно. Энэхүү журмын 4.8-д заасан нь шинжээчид нэгэн адил хамаарна.

5.2. Ашигт малтмалын тухай хуулийн 16-д заасан улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгүүлэх геологийн судалгаа, эрдэм шинжилгээний ажлын тайлан, 48.4-т заасны дагуу ордын нөөц, эрэл, хайгуулын үр дүнгийн тайлан, орд ашиглах болон боловсруулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс энэ журмын 5.1-т заасан шинжээчийг томилж ажиллуулна.

5.3. Шинжээчийн эрх олгогдсон мэргэшсэн мэргэжилтний нэр, мэргэшлийн чиглэл ил тод байна.

5.4. Геологийн судалгааны ажлын эцсийн үр дүнгийн тайлан /эрдэм шинжилгээ, зураглал, эрэл, хайгуул гм/ -д дүгнэлт гаргах шинжээч нь тухайн тайлан зааврын дагуу зохиогдсон эсэх, тухайн дүүрэгт тархсан интрузив бүрдэл, давхарга зүйд хамрагдах хурдас чулуулгийг гарал үүсэл, насны ангиллаар нь ангилсан үндэслэл, талбайн шлих, геохимийн зэрэг сорьцлолтын аргачлал, үр дүнг боловсруулсан байдал, талбайн металлогений үнэлгээ, геофизикийн судалгааны ажлын аргачлал, үр дүнг боловсруулсан байдал, геологийн зураг, тэдгээрийн таних тэмдэгийг зохих зааврын дагуу хийсэн байдал зэргийг нягтлан, дүгнэлт, шүүмж өгсөн байна.

5.5. Ашигт малтмалын ордыг ашиглах болон баяжуулах техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт гаргах шинжээч ашигт малтмалын хүдрийг олборлох ил, далд уурхайн аргаар болон уламжлалт бус /уусгалтын болон бусад/ аргаар байгуулах хүдэр олборлох, баяжуулах, цэвэршүүлэх технологийн болон үйлдвэрлэлийн техник, технологийн параметрийг оновчлон сонгох, хөрөнгө оруулалт, эдийн засгийн үр ашгийн тооцоо, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх тооцоо, судалгаа зэрэгт дүгнэлт гаргана.

5.6. Геологи хайгуулын ажлын үр дүнгээр боловсруулсан ашигт малтмалын нөөцийн тооцоотой тайланд дүгнэлт гаргах шинжээч нь ашигт малтмал, газрын тосны хайгуулын ажлын сонгосон аргачлал оновчтой эсэх, нөөцийн тооцооны үндсэн үзүүлэлтүүд үндэслэлтэй эсэх, холбогдох хэмжилт, лабораторын шинжилгээний баталгаажилт, тооцооны материал, зураг, зүсэлт бүрэн, бодитой байгаа эсэх, гидрогеологи, эдийн засгийн үр ашигтай байх олборлолтын технологи, түүнд үндэслэсэн нөөцийн хүрээг тодорхойлсон байдал болон хүдэр боловсруулах технологийг судалсан байдал зэрэг нь зохих аргачлалын дагуу хийгдсэн эсэх, техник, эдийн засгийн урьдчилсан үнэлгээний тооцоолол нь үнэн зөв, тавигдах шаардлагын дагуу тайлан зохиогдсон эсэхэд дүгнэлт, зөвлөмж өгнө.

5.7. Дараах тохиолдолд шинжээчийн эрхийг мэргэшсэн мэргэжилтний зөвлөлийн шийдвэрээр цуцална:

5.7.1. Тухайн шинжээчийн шүүмж бичиж, дүгнэлт гаргасан геологийн судалгааны ажлын эцсийн үр дүнгийн тайлан /эрдэм шинжилгээ, зураглал, эрэл, хайгуул гм/ болон техник эдийн засгийн үндэслэл нь 3 болон түүнээс дээш удаа хууль тогтоомжоор тавигдсан шаардлагыг хангаагүй буцаагдсан, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл хүлээн авахаас татгалзсан эсхүл энэхүү журмын 6.2-т заасныг зөрчсөн тухай Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн тэмдэглэлд 3 болон түүнээс дээш удаа дурьдагдсан бол Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн саналыг үндэслэж;

4.7.2 Албан ёсоор шинжээчээр томилогдохоос удаа дараа тодорхой шалтгаангүйгээр татгалзсан эсхүл журмаар тогтоосон аргачлалын дагуу тооцогдох шинжээчийн хөлснөөс их хэмжээний хөлс нэхсэн;

4.7.3. Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг зөрчсөн тохиолдолд мэргэшлийн зэргийг төрийн бус байгууллагын ёс зүй ба гомдол хэлэлцэх хороо, мэргэшсэн мэргэжилтний зөвлөлийн саналыг үндэслэж;

Зургаа. Мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн ёс зүйн ерөнхий зарчим

6.1. Мэргэшсэн мэргэжилтэн, шинжээч нь мэргэжлийн ажил, үйлчилгээ үзүүлэн шинжээчээр ажиллахдаа шударга ёс, ёс зүйг баримталж, мэргэжлийн чадвар, хараат бус байдлыг эрхэмлэн мэдээллийн нууцыг хадгалах, техник, технологийн зохих арга зүйн стандартуудыг баримтлах, мэргэжлийн нэр хүндийг дээдлэх зэрэг зарчмуудыг баримтална.

6.2. Мэргэшсэн, зөвлөх мэргэжилтэн нь зөвхөн өөрийн мэргэшсэн мэргэшлийн чиглэлээр шинжээчээр зөвлөх үйлчилгээ үзүүлж ажиллах бөгөөд энэхүү журамд дурьдсанаас өөр аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

Долоо. Хэрэгжилтэд тавих хяналт

7.1. Төрийн бус байгууллага нь үйл ажиллагааны нэгдсэн тайланг жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

7.2. Энэхүү журамтай холбоотой аливаа гомдол, хүсэлтийг төрийн захиргааны төв байгууллагад гаргах бөгөөд хэрэв төрийн захиргааны төв байгууллагын гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд хандан шийдвэрлүүлнэ.

--- оОо ---